**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2025/083/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br><br>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Я.Алтанцэцэг<br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н:Баттогоо<br>Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn<br>Аудитор: Р.Баярмаа<br>Утас: 325093 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 25 № 01/165

танай ____________-ны № ____________-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.АРИУНБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд 19 ангиллаар “Ур чадвар-2024” уралдааныг зохион байгуулж давхардсан тоогоор 450 гаруй багш оролцсон байна. СӨБ-ын “Багш солилцоо” хөтөлбөрийн хүрээнд 14 аймаг, дүүргийн цэцэрлэгийн 114 багшийн арга зүй, туршлага хуваалцсан ба ёс заншлаа дээдлэн, ардын өв уламжлалаас суралцах зорилготой “Би Монгол хүүхэд” аяныг 33 цэцэрлэгийн 150 бүлгийн 3750 хүүхэд, 2500 эцэг эхийн оролцоотой хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор байршуулаагүй, цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 42 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 95 хувьтай гэж тайлагнасан байна.

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.CHD BH.docx

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.CHD.BH..docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,686,916.86** | **5,018,319.58** |
| **33** | **АВЛАГА** | 164,616.44 | 703,259.16 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 164,616.44 | 703,259.16 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,522,300.42 | 4,315,060.42 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,522,300.42 | 4,315,060.42 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,218,950.00 | 215,010.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 445,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,303,350.42 | 3,655,050.42 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **100,127,948.3** | **95,257,121.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 100,127,948.30 | 95,257,121.32 |
| **392** | **Биет хөрөнгө** | 59,711,023.30 | 54,840,196.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 61,891,427.80 | 74,910,372.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,639,765.16) | (28,983,993.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,827,777.20 | 19,250,493.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,368,416.54) | (10,336,676.71) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,416,925.00 | 40,416,925.00 |
| 39301 | Программ хангамж | 935,000.00 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (935,000.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,416,925.00 | 40,416,925.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **104,814,865.16** | **100,275,440.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,518,525.58** | **721,861.72** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,518,525.58 | 721,861.72 |
| **413** | **Өглөг** | 4,518,525.58 | 721,861.72 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,518,525.58 | 721,861.72 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **100,296,339.58** | **99,553,579.18** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 100,296,339.58 | 99,553,579.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 15,969,433.87 | 15,969,433.87 |
| 51101 | Өмч: - төрийн | 15,969,433.87 | 15,969,433.87 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 84,326,905.71 | 83,584,145.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 88,078,038.96 | 84,326,905.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (3,751,133.25) | (742,760.40) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **104,814,865.16** | **100,275,440.90** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **435,929,973.16** | **363,707,245.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **189,742,673.16** | **13,420,245.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 189,742,673.16 | 13,420,245.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 22,242,512.30 | 13,420,245.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 167,500,160.86 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **246,187,300.00** | **350,287,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,802,300.00 | 332,699,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,802,300.00 | 332,699,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,385,000.00 | 17,588,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 10,068,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,385,000.00 | 7,520,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **439,681,106.41** | **364,450,005.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **439,681,106.41** | **364,450,005.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 438,005,616.55 | 331,821,524.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 176,625,644.16 | 251,443,154.34 |
| 210101 | Үндсэн цалин | 118,010,642.53 | 162,300,872.56 |
| 210102 | Нэмэгдэл | 15,421,524.67 | 17,984,881.78 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,745,000.00 | 50,134,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,448,476.96 | 21,023,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,610,830.24 | 31,295,291.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,027,172.19 | 21,337,268.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,767,902.65 | 2,468,744.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,265,068.44 | 1,234,372.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 309,878.86 | 1,234,372.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,240,808.10 | 5,020,533.65 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 206,876,156.08 | 3,248,275.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,212,232.00 | 2,619,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 933,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 390,506.27 | 221,635.70 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,215,470.00 | 407,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 388,474.00 | - |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 202,736,473.81 | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | 779,731.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 779,731.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 492,000.00 | 10,541,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,000.00 | 10,101,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 352,000.00 | 440,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,400,986.07 | 34,514,071.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 583,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,874,000.00 | 15,640,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,526,986.07 | 18,291,071.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,675,489.86 | 32,628,480.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,175,489.86 | 32,628,480.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,175,489.86 | 32,628,480.96 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(3,751,133.25)** | **(742,760.40)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,751,133.25)** | **(742,760.40)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **246,187,300.00** | **350,287,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **246,187,300.00** | **350,287,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,802,300.00 | 332,699,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 229,802,300.00 | 332,699,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,385,000.00 | 17,588,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 10,068,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,385,000.00 | 7,520,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **226,008,400.00** | **350,287,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **226,008,400.00** | **350,287,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **224,332,910.14** | **317,658,519.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 172,147,800.00 | 255,946,145.95 |
| 210101 | Үндсэн цалин | 114,244,129.53 | 166,803,864.17 |
| 210102 | Нэмэгдэл | 15,308,772.15 | 17,984,881.78 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,287,003.36 | 50,134,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,307,894.96 | 21,023,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,760,083.87 | 31,127,606.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,027,172.19 | 21,169,583.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,767,902.64 | 2,468,744.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,414,322.07 | 1,234,372.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 309,878.86 | 1,234,372.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,240,808.11 | 5,020,533.65 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,946,926.27 | 4,403,766.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,571,150.00 | 1,542,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 445,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 390,506.27 | 221,635.70 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,985,270.00 | 2,194,431.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 112,100.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 112,100.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 492,000.00 | 10,541,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 140,000.00 | 10,101,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 352,000.00 | 440,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,874,000.00 | 15,640,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,874,000.00 | 15,640,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,675,489.86** | **32,628,480.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,175,489.86 | 32,628,480.96 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,175,489.86 | 32,628,480.96 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,178,900.00** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,178,900.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,178,900.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,178,900.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,178,900.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(20,178,900.00)** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (0.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 15,969,433.87 | 0.00 | 88,078,038.96 | 104,047,472.83 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **15,969,433.87** | **0.00** | **88,078,038.96** | **104,047,472.83** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (3,751,133.25) | (3,751,133.25) |
| C08 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,969,433.87** | **0.00** | **84,326,905.71** | **100,296,339.58** |
| D01 | **2014 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **15,969,433.87** | **0.00** | **84,326,905.71** | **100,296,339.58** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **15,969,433.87** | **0.00** | **84,326,905.71** | **100,296,339.58** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (742,760.40) | (742,760.40) |
| D09 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,969,433.87** | **0.00** | **83,584,145.31** | **99,553,579.18** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 278,694,900.00 | 255,946,145.95 | 22,748,754.05 | 91.8 |
| 210101 | Үндсэн цалин | 173,270,300.00 | 166,803,864.17 | 6,466,435.83 | 96.3 |
| 210102 | Нэмэгдэл | 70,300,800.00 | 17,984,881.78 | 52,315,918.22 | 25.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,244,100.00 | 50,134,000.00 | (35,889,900.00) | 352.0 |
| 210104 | Урамшуулал | 20,879,700.00 | 21,023,400.00 | (143,700.00) | 100.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,463,300.00 | 31,127,606.39 | 9,335,693.61 | 76.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,355,500.00 | 21,169,583.04 | 8,185,916.96 | 72.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,776,900.00 | 2,468,744.84 | 308,155.16 | 88.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,388,500.00 | 1,234,372.43 | 154,127.57 | 88.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,388,500.00 | 1,234,372.43 | 154,127.57 | 88.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,553,900.00 | 5,020,533.65 | 533,366.35 | 90.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,446,900.00 | 4,403,766.70 | 43,133.30 | 99.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,546,000.00 | 1,542,700.00 | 3,300.00 | 99.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 448,700.00 | 445,000.00 | 3,700.00 | 99.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 199,000.00 | 221,635.70 | (22,635.70) | 111.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,253,200.00 | 2,194,431.00 | 58,769.00 | 97.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 134,900.00 | - | 134,900.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 134,900.00 | - | 134,900.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 690,600.00 | 473,000.00 | 217,600.00 | 68.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 167,400.00 | 33,000.00 | 134,400.00 | 19.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 523,200.00 | 440,000.00 | 83,200.00 | 84.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,268,400.00 | 8,120,000.00 | 148,400.00 | 98.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,268,400.00 | 8,120,000.00 | 148,400.00 | 98.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 332,699,000.00 | 300,070,519.04 | 32,628,480.96 | 90.2 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 10.00 | 10.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **10.00** | **10.00** | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 10.00 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **17,588,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **17,588,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **17,588,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,588,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,068,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,068,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,520,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 7,520,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **17,588,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | **17,588,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,068,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 156,399.0 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 6,616.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах 703.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 5,913.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,616.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,176.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг дутуу тайлагнасан. | 1 | 32,628.5 | 1 | 32,628.5 | | | 1 | 32,628.5 | | | | |
| Албан хаагчдын цалингаас тооцож суутгасан ХХОАТ-ыг тайлагнаагүй. | 1 | 320.2 | 1 | 320.2 | | | 1 | 320.2 | | | | |
| Нэг албан хаагчийн ээлжийн амралтын олговор, шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан. | 1 | 2,679.5 | 1 | 2,679.5 | | | 1 | 2,679.5 | | | | |
| Сургуулиудад тараасан сурах бичгийг нөөцийн бараагаар бүртгэж тайлагнасан. | 1 | 118,284.6 | | | 1 | 118,284.6 | 1 | 118,284.6 | | | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд орлогод авч бүртгээгүй. | 1 | 2,486.3 | 1 | 2,486.3 | | | 1 | 2,486.3 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **5** | **156,399.1** | **4** | **38,114.5** | 1 | **118,284.6** | **5** | **156,399.1** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. | 1 | 703.2 | | | 1 | 703.2 | | | | | | |
| Акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгийг устгаж, акт үйлдээгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй. | 1 | 5,913.6 | | | | | 1 | 5,913.6 | | | | |
| Төрийн Аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлсэн санхүүгийн тайлангийн хугацааг хоцроож ирүүлсэн. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **3** | **6,616.8** | | | **1** | **703.2** | **2** | **5,913.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст 5 саяас дээш үнийн дүн бүхий 348,667.0 мянган төгрөгийн орлогын 14 гүйлгээ, 15,968.0 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах тухай 37,886.6 мянган төгрөгийн 11 шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй. | 1 | 402,521.6 | 1 | 402,521.6 | | |
| Дүн | 1 | 402,521.6 | 1 | 402,521.6 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн | 1 | - | | | 1 | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй. | | | | | | |
| Төсвийн шууд захирагч нь цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй, бараа материалын худалдан авалт хийсэн. | 1 | 1,640.4 | | | 1 | 1,640.4 |
| Дүн | 2 | 1,640.4 | | | 2 | 1,640.4 |
| **Нийт дүн** | **3** | **404,162.0** | **1** | **402,521.6** | **2** | **1,640.4** |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 74/А0270227 Улаанбаатар хот
НТАГ-2025/083/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэг албан хаагчид 703,259.16 (долоон зуун гурван мянга хоёр зуун тавин есөн төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн цалинг илүү олгож авлага үүсгэсэн ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 6.4.8-д "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.7-д "*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад* заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Албан хаагчид илүү цалин олгосноос үүссэн авлагыг барагдуулж, төсөвт төвлөрүүлж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ариунболд, нягтлан бодогч Х.Ариунтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АУДИТОР Р.БАЯРМАА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043276

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 77/А0270227 Улаанбаатар хот

НТАГ-2025/815/НА-СТА-ТШЗ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст 5 саяас дээш үнийн дүн бүхий 348,667,000.00 төгрөгийн орлогын 14 гүйлгээ, 15,968,000.00 төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах тухай 37,886,600.00 төгрөгийн 11 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд "Шилэн дансны мэдээлэл", 6.4-д "*энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.4-д "*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*", 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*", 6.4.8-д "*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад асуудал*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Шилэн дансны мэдээллийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ариунболд, нягтлан бодогч Х.Ариунтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

АУДИТОР Р.БАЯРМАА

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043277